



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 188

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6, 4 дэх заалт, Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны А/157 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 5,019,008,019.00 (таван тэрбум арван есөн сая найман мянга арван есөн) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит хувьцаат компанид эзэмшүүлж үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Э.Баатарсан, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цогтсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132006074
26-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн
.....488..... дугаар тогтоолын хавсралт

"Улаангомьн дулааны хоёрдугаар станц" төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Байршил	Улсын комиссын актын огноо, дугаар
1	УДДТ-2-ын 2-р хэлхээний дулааны шугам	2020.11.30	метр	500	398,162,878.00	Улаангом сум 5-р баг	2020.11.30 дугаар 2020
2	УДДТ-11-ын 2-р хэлхээний дулааны шугам	2020.11.05	метр	706	570,518,200.00	Улаангом сум 4-р баг	2020.11.05 дугаар 2021
3	УДДТ-5-ын 2-р хэлхээний шугам шинэчлэл, УДДТ-12-ын 2-р хэлхээний дулааны шугам	2020.11.10	метр	578	462,518,323.00	Улаангом сум 11,7-р баг	2020.11.10 дугаар 2020
4	УДДТ-13-ын 2-р хэлхээний дулааны шугам	2020.12.23	метр	1300	929,316,456.00	Улаангом сум 6-р баг	2020.12.23 дугаар 2020
5	УДДТ-1-ын 2-р хэлхээний дулааны шугам	2020.11.06	метр	716	672,017,563.00	Улаангом сум 7-р баг	2020.11.06 дугаар 2020
6	УДДТ-3-ын 2-р хэлхээний дулааны шугам	2020.12.07	метр	391	451,776,458.00	Улаангом сум 4-р баг	2020.12.07 дугаар 2020

7	УДДТ-9-ын засвар, дМ-н өргөтгөл, гадна, дотор цахилгаан шинэчлэл 1,2-р хэлхээний дулааны шугам	2020.11.23	метр	639.4	784,698,141.00	Улаангом сум 5-р баг	2020.11.23 дугаар 69/2020
8	Утаа шүүх фильтр	2021.07.29	ш	2	750,000,000.00	Улаангомын Дулааны 2-р станцын К1, К2 зуух	2021.07.29 дугаар ОББҮХ/2020-08
	Нийт дүн			4832	5,019,008,019.00		
				(дөрвөн мянга найман зуун гучин хоёр)	(таван тэрбум арван есөн сая найман мянга арван ес)		